



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сонжин групп ХХК-ний "Сонжин гранд" зочид буудлын 15/069, Сод трейд ХХК-ний "Сод" зочид буудлын 16/043, Эль хаус ХХК-ний "Эль хаус" зочид буудлын 16/048, Текко ХХК-ний "Хаан" зочид буудлын 14/55, Алтаннارانтрейд ХХК-ний "247" зочид буудлын 16/056, Алтаннارانтрейд ХХК-ний "Эрхэс" зочид буудлын 16/057, Зүүнбаян рейфайнери ХХК-ний "Пийс бридж" зочид буудлын 16/076, Экостар ХХК-ний "Экостар" зочид буудлын 13/016, Экостар ХХК-ний "Экостар" зочид буудлын 16/060 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Balma* Д.БАТСҮХ



1150500267

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 09 сарын 04
өдрийн А/Б дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.09.04

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|--------------|--|
| 1 | Сонжин групп ХХК | 5051479 | Сонжин гранд | БЗД-ийн 13-р хороо Энхтайваны өргөн чөлөө |
| 2 | Текко ХХК | 2595028 | Хаан | СБД-ийн 10-р хороо Их тойруу-22 |
| 3 | Эль хаус ХХК | 2856352 | Эль хаус | БГД-ийн 17-р хороо Амарсанаагийн гудамж 23-1 |
| 4 | Сэц Мэлмий ХХК | 5195411 | Шинэ өглөө | БГД-ийн 5-р хороо 10-р хороолол ЭТӨЧ-83/1 |
| 5 | Сод трейд ХХК | 2021056 | Сод | БГД-ийн 10-р хороолол 5-р хороо ЭТӨЧ-46/12 |
| 6 | Алтаннارانтрейд ХХК | 2548542 | Эрхэс | БГД-ийн 12-р хороо Хасбаатарын -3а |
| 7 | Алтаннارانтрейд ХХК | | 247 | БГД-ийн 12-р хороо Хасбаатарын -3б |
| 8 | Зүүнбаян рейфайнери ХХК | 2637634 | Пийс бридж | ХУД-ийн 1-р хороо Дундгол гудамж-47 |
| 9 | Экостар ХХК | 5088275 | Экостар | СБД-ийн 8-р хороо Бага тойруу 46/4 |
| 10 | Экостар ХХК | 5088275 | Экостар | БГД-ийн 5-р хороо ЭӨЧ-91/04 |

-ооОоо-